



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/180

Арвайхээр сум

Батлан хамгаалахын хууль тогтоомж,  
шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт,  
зөвлөн туслах ажил явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм"-ийн 3.1, 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт, зөвлөн туслах ажил явуулах комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилтэд хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг чанартай зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа А.Нямхүү)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0364

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 08-ны өдрийн 11180 дугаар  
захирамжийн хавсралт



**ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖИЛ  
ЯВУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Нямхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Гишүүдэд:

Ч.Ванчинсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа)

Р.Цэрэндэжид (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ахлах мэргэжилтэн, Улсын дайчилгааны мэргэжилтэн, бэлтгэл дэслэгч)

З.Нацагням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ч.Адъяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер, дэд хурандаа)

-оОо-